

ШИЛЖИН БАЙРШИХ ХҮСЭЛТ ИЛГЭЭХ ЗААВАР

- Шилжин байрших хүсэлтийг www.tzmoh.gov.mn бүртгэл, зөвшөөрлийн цахим хуудсаар илгээнэ. /“нэмэлт өөрчлөлт” цэснээс “хаягийн өөрчлөлт” сонголтыг сонгон хүсэлтээ илгээнэ/
- Цахим хуудаст байгууллагын тоон гарын үсгээр нэвтрэх ба тоон гарын үсэг олгох зөвшөөрөлтэй байгууллагаас тоон гарын үсэг авна. /татвар, нийгмийн даатгалын системд нэвтрэх тоон гарын үсгээр нэвтрэх боломжгүй тул шинээр авна/
- Хүсэлт илгээхтэй холбоотой тодруулах зүйлийг 77990101(1), 75116420 дугаарын утаснаас лавлана уу.

Бүрдүүлэх материал:

1. Албан хүсэлт
2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
3. Компанийн дүрмийн хуулбар
4. Эмийн аюулгүй байдлын мэдээ /зөвхөн эмийн санд хамаарна/
5. Эрүүл мэндийн ажилтны үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн диплом, лицензийн хуулбар
6. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан /сүүлийн 3 жилээр/
7. Аж ахуйн нэгжийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт
8. Үйл ажиллагааны тайлан /www.tailan.ubhealth.mn хаягаар илгээдэг жилийн эцсийн тайлан, сүүлийн 3 жилээр/

Хувийн ортой эмнэлэг, клиник, сувилал:

- Хувийн эмнэлгийн үйл ажиллагааны тайлан ЭМТ-202
- Сувиллын байгууллагын үйл ажиллагааны тайлан ЭМТ-203
- БЗДХ-ын кабинетийн үйл ажиллагааны тайланг ЭМТ-305
- Нүүр амны кабинетийн үйл ажиллагааны тайлан ЭМТ-309
- Арьсны кабинетийн үйл ажиллагааны тайлан ЭМТ-312

Эмийн сан нь үйл ажиллагааны тайланг хувийн эмнэлгийн үйл ажиллагааны тайлангийн ЭМТ-201.27-1, 2, 3 маягтаар өгнө. Үүнд:

- 201.27.1- Хүлээн авсан жорын тоо, төрлөөр
 - 201.27.2- Борлуулалтын орлого
 - 201.27.3 – Эмийн нөөцийн тайлан
9. Гадаад болон дотоод схем зураг /байршил болон өрөөний зохион байгуулалт, хэмжээг тусгасан байх/
 10. Хүний нөөц, тоног төхөөрөмжийн жагсаалт /ЭМС-ын 2013 оны 145 дугаар тушаалын хүснэгт №2, №3-ын дагуу/
 11. Түрээсээр ажлын байрыг бэлтгэх бол түрээсийн гэрээ, үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар; өөрийн байр бол үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
 12. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
 13. Эмнэлэг, эмийн сан, АШМУХҮ-ний ажлын байр үйлчилгээний зориулалттай үл хөдлөхийн гэрчилгээтэй байх